

“Шавардлага ба дотор заслын ажил”

Хөдөлмөр хамгаалал эрүүл ахуйн чухал цэгүүд


барилгын үед болгоомжлох тэмдэглэл (өргүүрийн тавцан, эвхдэг шаттай өргүүрт тавцан)

(1) Материалыг зөөвөрлөх үеийн болгоомжлол

Вагон тэрэг, бетон зуурмагийн тэрэг гэх мэтийг материал зөөвөрлөхөд ашигла. Үүнийг хүчээр зөөвөрлөх нь нурууг чинь гэмтээж болзошгүй. Нурууны доод хэсэгт очих ачааллыг аль болох багасгахыг хичээгээрэй.


[Хүнд юм авч явах үед]

Биеийн хүндийн төв болон тухайн зүйлийн хүндийн төв нь нэг босоо шугамд байх ёстой.



Хэрхэн зөөвөрлөх вэ

Биеийн хүндийн төв болон тухайн зүйлийн хүндийн төв нь аль болох ойр байх ёстой.



Хэрхэн барих вэ



(2) Эвхдэг шат ба зөөврийн ажлын тавцаны аюулгүйн хэрэглээ

- Эвхдэг шат ба зөөврийн ажлын тавцанг тэгш гадаргуу дээр байрлуулж, түгжээг зогсох хүртэл нээнэ.
- Эвхдэг шатны өргүүрийн тавцангийн ажлын тавцанг гурван цэгээр тулж, тус бүрдээ 1.8м ба түүнээс бага байх ёстой бөгөөд тулах цэгийн хооронд хоёр хүнээс олон хүн орохгүй байх ёстой.
- Эвхдэг шатны өргүүрийн тавцангийн угсралтыг тусгай боловсрол эзэмшсэн хүн гүйцэтгэнэ.

[Эвхдэг шатны өргүүрийн тавцангийн жишээ]



(3) Зөөврийн ажлын тавцан дээр аюулгүй гарч, доошоо буугаарай


- Эхлээд багаж хэрэгсэл, материалуудаа өргүүрийн тавцан дээр тавиад, аажмаар босоод, гар бариулын төмөр юмуу гишгүүрээс барьж буу.
- Ажлын тавцан руу нуруугаараа харуулж дээшээ гарах юмуу доошоо бууж болохгүй.



Дээшээ доошоо явахдаа гар бариулыг ашигла


(4) Юмсыг цэвэр, эмх цэгцтэй тавь

Зөөврийн ажлын тавцанг гарцад ашиглахдаа бүх юмаа сайтар цэгцэлбэл ажилчид гарцыг ашиглах боломжтой болно.



(5) Хоёр гар, хөлөө ашиглан шатаар дээр дээш, доошоо явах


Хэрэв та хоёр гартаа нийвий юмуу нийвийний хавтан бариад эвхэгддэг шатаар дээш доош явбал та тэнцвэрээ алдаж унана. Дээш доош явахдаа ачаа бүү зөө, хоёр гар, хөлөөрөө гурван цэгийн тулгуур хий.





(6) Эвхдэг шатыг аюулгүй ашиглах

Хэрэв та эвхдэг шатны гишгүүр юмуу дээд хавтан дээр дамнан зогсож байвал та тэнцвэрээ алдаж, өнхөрч/доош унах магадлалтай. Үүнийг зөв ашиглаж үзье.

- Шатны гишгүүр юмуу дээд хавтан дээр дамнан бүү зогс.




- × Шатны дээд гишгүүр дээр дамнан зогсох



(7) Эвхэгддэг шатан дээр шаардлагагүй зүйлийг бүү тавь

Өргүүр тавцан дээрээс хана дуусгасан үед багажууд санамсаргүй унадаг учраас өргүүр тавцан дээр ямар нэгэн багаж юмуу шаардлагагүй зүйлүүд байгаа эсэхийг хөлөөрөө сайтар шалга. Мөн хөлийн хуруу юмуу аюулгүйн тор суурилуул.



(8) Хөмрөх осол гарахаас болгоомжил!

Хэрэв багаж шалан дээр үлдсэн юмуу эсвэл таныг харагдуулахгүй далдалдаг том зүйлийг барьж ажиллаж байгаа бол "бүдэрч унах" эсвэл "шатнаас унах" магадлал өндөр болно.

Явган алхах газарт юм үлдээгээгүй, хөлөө харагдахгүй байдлаар ажиллахгүй байх.

